



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН СОЁЛЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Тайландын Вант Улсын Засгийн газар (цаашид "талууд" гэх);

Хоёр орны соёлын харилцааг харилцан сайжруулж, соёлын талаархи боломж, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор соёл, урлагийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэн,

Соёлын салбар дахь найрсаг харилцааг бэхжүүлэхийг анхаарч,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Талууд соёл, урлагийн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргаж, эл зорилгоор дараахь зүйлсийг дэмжинэ:

хоёр оронд урлагийн наадам болон соёлын бусад үйл ажиллагааг зохион байгуулах,
урлагийн бүтээлийн үзэсгэлэн харилцан солилцох,
соёл, урлагийн салбар дахь симпозиум, бага хурал, семинар болон соёлын бусад арга хэмжээнд мэргэжилтнүүдийг оролцуулах,
соёлын өв, түүхийн дурсгалт зүйлсийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах чиглэлээр мэргэжилтэн солилцох,
талуудын хооронд соёлын хамтын ажиллагааг бэхжүүлэх хамтын ажиллагааны бусад хэлбэр.

2 дугаар зүйл

Талууд театр, музей, номын сан зэрэг соёл, урлагийн холбогдох байгууллагууд болон соёлын дурсгалт зүйлсийг хадгалж, хамгаалах үүрэг бүхий байгууллага хоорондын шууд хамтын ажиллагааг дэмжинэ. Энэхүү хамтын ажиллагаа нь талуудын соёл, урлагийн байгууллагуудын хооронд тусдаа шууд байгуулсан хэлэлцээрийг үндэслэн хэрэгжинэ.

3 дугаар зүйл

Талууд соёл, урлагийн чиглэлээр жилд 1-2 оюутныг санхүүжилтийн боломжоос хамааран харилцан солилцоно.



4 дүгээр зүйл

Талууд кино урлагийн салбарт бүх талын хамтын ажиллагааг дэмжинэ.

5 дугаар зүйл

Талууд өөрсдийн спортын байгууллага, нийгэмлэгүүд хоорондын харилцааг дэмжих, түүнчлэн тэмцээн, уулзалт болон холбогдох бусад үйл ажиллагаанд оролцох тамирчид, баг, бусад бие бүрэлдэхүүнийг солилцох замаар спорт, биеийн тамирын боловсролын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хүчин чармайлт гаргана.

6 дугаар зүйл

Олон улсын эрх зүй болон талуудын үндэсний хууль тогтоомжийн дагуу талууд соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр оруулах, гаргах үйлдлийг таслан зогсоох хамтарсан арга хэмжээ авах боломжийг авч үзэх бөгөөд дурдсан асуудлаар мэдээлэл, туршлага харилцан солилцоно.

7 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор талуудын холбогдох эрх бүхий байгууллагууд соёлын салбарт хамтран ажиллах тодорхой төлөвлөгөөг боловсруулж, баталж болно.

Уг төлөвлөгөөнд харилцан тохиролцох замаар нэмэлт өөрчлөлт оруулж болно.

8 дугаар зүйл

Талууд соёлын хамтын ажиллагааны санхүүгийн нөхцлийг хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу тогтоож, батлахаар тохиролцов.

Уран сайхны хамтлагийн тоглолт, үзэсгэлэнгийн бүтээлийг арилжааны болон арилжааны бус хэлбэрээр харилцан солилцож болно.

9 дүгээр зүйл

Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ нь хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

10 дугаар зүйл

Талууд энэхүү хэлэлцээрийг тайлбарлахтай холбогдон үүссэн бүх маргааныг харилцан зөвшилцөж, хэлэлцээ хийх замаар шийдвэрлэнэ.


11 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээр түүнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд таван жилийн хугацаанд хүчинтэй байна. Аль нэг тал энэхүү

хэлэлцээрийн хугацаа дуусахаас зургаан сарын өмнө Хэлэлцээрийг хүчингүй болгох тухай бичгээр нөгөө талдаа мэдэгдээгүй бол цаашид таван жил тутам аяндаа сунгагдана.


Энэхүү хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 2006 оны 8 дугаар сарын 17-ны өдөр монгол, тай, англи хэлээр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд бүх эх бичвэр нь адил хүчинтэй. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛӨН**



Нямаагийн Энхболд
Гадаад хэргийн сайд

**ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛӨН**



Кантати Супамонгкон
Гадаад хэргийн сайд